МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 29 өдөр Дугаар А/602 Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.7 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 144 дүгээр зарлигийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Алтай хотод 2020 оны 10 дугаар сарын 31-нээс 11 дүгээр сарын 02-ны өдрүүдэд болох эмэгтэй хөл бөмбөг хөгжүүлэх “Grassroots” фестиваль-сургалтыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Алтайбаатар -Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:Л.Хатанбаатар -Боловсрол, соёлын газрын мэргэжилтэн, аймгийн Хөлбөмбөгийн холбооны нарийн бичгийн дарга

Гишүүд:
Р.Батмөнх -Боловсрол, соёлын газрын дарга
Н.Бямбацогт -Биеийн тамир, спортын газрын дарга
Д.Анхбаатар -Аймгийн хөл бөмбөгийн холбооны тэргүүлэгч
Б.Мөнх-Эрдэнэ-Дэлгэр сумын сургуулийн тамирын багш, хөлмбөгийн дасгалжуулагч

2.“Grassroots” фестиваль-сургалтыг нэгдсэн удирдлагаар хангаж, сургалтын үр дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Алтайбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ГАНБАТ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc